



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 11 сарын 09
өдрийн 5535 дугаарт бүртгэгдсэн

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дүгээр 5/17
7/17

ГОМГОН

Үл хөдлөх эд хөрөнгийн татварын
хувь хэмжээ шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.2-ын "д", 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөгдөх Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Аймгийн хэмжээнд үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, татвар төлөх хуулийн этгээд хийгээд татвар ногдох үл хөдлөх эд хөрөнгийн талаарх судалгаа, мэдээллийг нарийвчлан гаргаж, шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Тогтоол хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 116 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

0121038

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус
 V хуралдааны 5/17 дүгээр тогтоолын хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТАТВАРЫН ХУВЬ
 ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх эд хөрөнгийн төрлүүд	Хөрөнгийн нийт үнэлгээнд ногдуулах албан татварын хэмжээ /хувь/	
		Аймгийн төв Баянхонгор сум	Бусад сум
1	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.6%	0.6%
2	Газар тариалан, мал болон байгалийн гаралтай түүхий эд, боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.6%	0.6%
3	Төрийн бус байгууллага, Сан, Шашин сүм хийдийн зориулалттай болон ийм зориулалтаар ашиглагдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.6%	0.6%
4	Уул уурхай, ашигт малтмал боловсруулах үйлдвэрийн зориулалтаар ашиглагдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.0%	1.0%
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал боловсруулах үйлдвэрийн зориулалтаар ашиглагдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг уг хөрөнгийн татвар	0.9%	0.7%
6	Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх худалдан борлуулах болон ийм зориулалтаар ашиглагдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.0%	1.0%